



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 308

Улаанбаатар хот

“Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 2.3, 3.1, 3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Гүйцэтгэх захирал П.Ганхүүтэй байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг “Хангалтгүй” гэж дүгнэсүгэй.

2. “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал П.Ганхүүтэй байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг цуцлахыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд удирдамж болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Хянагч: ХАНГАЙ
Хянагч: ХАНГАЙ

132005500
13-r_huraldaan.docx